



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 154,311,800.00 (нэг зуун тавин дөрвөн сая гурван зуун арван нэгэн мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийд балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Зам тээвэрийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Алтанцэцэг, “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ю.Ганзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т хүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.Нарангэрэл

132001546

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн

28.... дугаар тогтоолын хавсралт

"СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, "АРХАНГАЙ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД  
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д      | Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо | Балансын үнс, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                          | Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг) | Цаашид ашиглах хугацаа (жил) |
|----------|---|--------------------------------------|---|---------------------------------|------------------------------|
| 1        | Лексус LX570, 05-67, УБҮ, JTJHY00W084002784 | 2008/2010                            | 154,311,800.00  | 8,800,000.00                    | 4                            |
| Нийт дүн |   |                                      | 154,311,800.00  | 8,800,000.00                    | 4                            |
|          |   |                                      | (нэг зуун тавин дөрвөн сая гурван зуун арван нэгэн мянга найман зуун) | (найман сая найман зуун мянган) | -                            |